

/ГЭМ ХОР УЧРУУЛСНЫ ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ/

Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн

анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах нь

_____оны _____сарын _____
сум

Сайншанд

Нэхэмжлэгч: Дорж овогт Т. Ц, Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 баг Аюушийн 1-3 тоотод оршин суугч, ажлын газрын хаяг, албан тушаал, утас 99165874

Хариуцагч: Дамба овогт Ж.Ш, Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар баг Мааньзавын 11-25 тоотод оршин суугч, утас 70521425, 96008547, ажлын газрын хаяг, албан тушаал Шинэ хаягийг заавал бичих

Нэхэмжлэлийн шаардлага: 150000 төгрөг гаргуулах

Нэхэмжлэлийн үндэслэл: 2005.12.12-ны өдөр миний бие ДГА 12-15 улсын дугаарын Excel маркийн машинтай вокзалын зогсоол дээр зогсож байтал ДГА 78-98 улсын дугаартай УАЗ-469 маркийн машинтай Ж.Ш нь миний машины баруун ар талаас ухрах үйлдэл хийж байх үедээ мөргөн арын гэрэл болон куперийг хагалж гэмтэл учруулсан болно. Уг хохирол нь арын гэрэл 50.000 төгрөг, купер 100.000 төгрөг тус тус болсон. Гэтэл Ж.Ш нь одоо болтол миний хохиролыг барагдуулах нь битгий хэл намайг хэл амаар доромжлон өгөхгүй байна. Иймд Ж.Ш-с гэм хорын хохирол 150.000 төгрөг гаргуулан намайг хохиролгүй болгож өгнө үү.

Нэхэмжлэл гаргасан:

Т.Ц

Нэхэмжлэлд хавсаргасан материал:

- 1.Нэхэмжлэл 2 хувь
- 2.Эвдэрсэн зүйлийн үнэлгээ тогтоолгосон баримт
- 3.Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- 4.Иргэний үнэмлэхний хуулбар /нотариатаар батлуулах/

Улсын тэмдэгтийн хураамж төлөхдөө шүүхэд хандах болон Дорноговь аймгийн Татварын газарт хандан төлбөрийн даалгавар үүсгүүлж хураамжаа банкинд тушаана.

Шүүхийн утас: 70522144, 92172020

Анхаарах:/Та цаасны зүүн захаас 30 мм, дээд, доод захаас 20мм, баруун захаас 15 мм зайтай бичнэ/

/Нотлох баримтыг эх хувиар нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргаж өгнө/